

БАТЛАВ: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
*д. Михаил* Х.ЭНХЦЭЦЭГ

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбад/, Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Төндөрийн бичиг баримтанд заавал бурдуулж ирэх материал:

- ❖ Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг хийлгэсэн байна.

Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга ажлыг хийж гүйцэтгэнэ. Дээрхи ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл (Зураг төслийн шифр: ЗТК-03/23), мөн стандарт, технологийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтанд оруулна.

Цэцэрлэгийн барилгын ажилд:

Барилгын угсралтын ажил гүйцэтгэх явцад барьцаалдуулах зуурмаг, шавардлага зэрэгт туршилт, сорилт, хяналт шалгалтыг талбай дээр ажлыг хийж гүйцэтгэж байх хугацаанд байвал зохино. Барилгад бүх материал нь улсын стандартад нийцсэн материал сонгосон байх шаардалагатай.

Төндөрт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын засварын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

### **Тус ажлын үндсэн зураг төсвээс:**

Гадна зам талбайн тохижилтын ажил 1,113,080,510 төгрөгийн ажлаас

Гадна хашаа төмөр хайс /м2/ 91,915,861 төгрөгийн ажил хийгдэнэ.

#### **Бусад ажил хийгдэхгүй.**

Халаалтын тогооны 326,459,151 төгрөгийн ажил хийгдэхгүй.

**Тоног төхөөрөмжийн нийт зардал :** 164,229,972 төгрөг Үүнээс:

Агаар сорох сэнс 250м3/цаг Н=30 Па хүчин чадалтай 748,670 төгрөг

Агаар сорох сэнс 3050м3/цаг Н=180 Па хүчин чадалтай 3,109,860 төгрөг

Агаарын дулаан хөшиг n=5кВт 5,183,100 төгрөг

Хүчний трансформатор ТМ-400/10/0.4 400кВт 22,460,100 төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэнэ. **Бусад тоног төхөөрөмжийг хасаж тооцсон болно.**

Магадлашгүй ажлыг зардлыг хэрхэн ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага болон хяналтын инженерт танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс гаргана. Зөвшөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно.

Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

3.Мөнхбаяр

A handwritten signature consisting of stylized characters and a large, prominent 'X' drawn through it.